



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 05

Баянбулаг

Хоршоо хөгжүүлэх сангийн
хяналтын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор олгосон зээлийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Б.Төгөлдөр- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Нарийн бичгийн дарга: Д.Энхтөр- Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Гишүүдэд: Д.Удвалгарав- Санхүү төрийн сангийн мэргэжилтэн

М.Адъяа- Иргэний төлөөлөл

Б.Буянхишиг- Төрийн бус байгууллын төлөөлөл

2.Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын гүйцэтгэлийн тайланг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Б.Төгөлдөр)-т үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Б.НАМГАРРЕНЧИН



648803014